

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АНАГААХ УХААНЫ ИННОВАЦИ, ТЕХНОЛОГИЙН
ХЭЛТСИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ САМДАНГИЙН ЭНХЦОЛМОНГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт								
Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ДАГАЛДАН ГАРАХ БОДЛОГЫН БАРИМТУУДЫГ БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛАХ								
1.1	Эрүүл мэндийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг: Анагаах ухааны салбарт оношлогоо, эмчилгээний шинэ арга турших, нэвтрүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх журам	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2011 оны 165 дугаар тушаалаар баталсан журам байдаг.	Журмын төслийг боловсруулж, яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.	Анагаах ухааны салбарт оношлогоо, эмчилгээний шинэ арга турших, нэвтрүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсэгт зөвлөгөө дэмжлэг үзүүлэх шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" А/11 дүгээр тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн гишүүдийн телеграм группыг үүсгэж, мэдээлэл солилцооны боломжийг хангасан. Ажлын хэсгийн ээлжит хурлыг 04 дүгээр сарын 18-ны өдөр хуралдуулсан. "Анагаах ухааны салбарт оношилгоо, эмчилгээний шинэ аргыг бүртгэх, баталгаажуулах, мэдэ элэл журам"-ын төслийн хувилбарыг боловсруулж, ажлын хэсгийн гишүүдэд тараасан ба саналуудыг нэгтгэж байна.	I-VI сар	80	
1.2	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг	Эрүүл мэндийн сайдын тушаал	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/491	Журмын төслийг боловсруулж, яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Эрүүл	Эрүүл мэндийн салбарт хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоонд ашиглах журмыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн "Ажлын	I-VI сар	80	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2.3.2.6-435): Эрүүл мэндийн салбарт хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоонд ашиглах журам		дүгээр тушаалаар баталсан.	мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.	хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" А/491 дүгээр тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн гишүүдийн мэдээлэл солилцоог хангах зорилгоор дундын телеграм группыг байгуулсан. Хиймэл оюун ухааны хэрэглээ харьцангуй шинэ технологи тул ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр хангах ажлыг эрчимтэй хийсэн. Тухайлбал: ДЭМБ-аас 2023 онд боловсруулж хэвлүүлсэн "Regulatory considerations on artificial intelligence for health" гэсэн 80 хуудастай номыг орчуулж, ажлын хэсгийн гишүүдийн ажлын хүрээнд ашиглаж байна. Мөн ЦХИХХЯ-наас зохион байгуулсан "Хиймэл оюун ухааны бэлэн байдлын үнэлгээ" сэдэвт хэлэлцүүлэгт ажлын хэсгийн гишүүдийг оролцуулсан. Мөн ЦХИХХЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран зохион байгуулсан "Data+AI Conference" буюу Их өгөгдөл+хиймэл оюун ухааны чуулга уулзалтад ажлын хэсгийн гишүүдийг оролцуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нийт 4 удаа (танхимаар 2 удаа, онлайнаар 2 удаа) хуралдуулсан. Хиймэл оюун ухааныг эрүүл мэндийн салбарт ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх баримт материалуудын (журмын төсөл, +хэд хэдэн тушаалын төсөл) төслийг боловсруулсан.		
2.1	Эрүүл мэндийн тусламж	Ажлын хэсгийн	"Эрүүл мэндийн	ЭМЯ-ны ШУТЗ-ийн хурлын шийдвэрийг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2025 оноос эхлэн нэвтрүүлэх дэвшилтэт	I-IV сар	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	үйлчилгээнд 2025 онд шинээр нэвтрүүлэх шаардлагатай орчин үеийн дэвшилтэт технологийн тэргүүлэх чиглэлийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна.	тушаал, удирдамж Хэлэлцүүлэг (тоогоор)	тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлох журам"-ыг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/508 дугаар тушаалаар баталсан.	Эрүүл мэндийн сайд, ШУТЗ-ийн даргаар батлуулсан. Тэргүүлэх чиглэл, түүнд нийцсэн төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.	технологийн тэргүүлэх чиглэлийн төсөл, тэргүүлэх чиглэлд нийцсэн төсөл арга хэмжээний саналын жагсаалтын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсэгт зөвлөгөө дэмжлэг үзүүлэх шинжээчдийн багийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ажлын удирдамжийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/121 дүгээр тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шинжээчдийн багийн бүрэлдэхүүн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2025 оноос нэвтрүүлэх дэвшилтэт технологийн тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулах чиглэлээр нийтдээ 3 удаа (2 удаа онлайн, 1 удаа танхимаар) хуралдаж, хувилбарыг боловсруулсан. Мөн дээрх хувилбарт нийцүүлэн хэрэгжүүлж болох төсөл, арга хэмжээний жагсаалтын төслийг боловсруулсан. ЭМЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хуралдуулж, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2025 оноос эхлэн нэвтрүүлэх дэвшилтэт технологийн тэргүүлэх чиглэлийн төсөл, тэргүүлэх чиглэлд нийцсэн төсөл арга хэмжээний саналын жагсаалтын төслийг танилцуулж, ШУТЗ-ийн гишүүдээр хэлэлцүүлж, санал хураалтаар 100% дэмжигдсэн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2025 оноос эхлэн нэвтрүүлэх дэвшилтэт технологийн тэргүүлэх чиглэлийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах тухай Эрүүл мэндийн сайд, ШУТЗ-ийн даргын №25/006 дугаар шийдвэрээр албажуулсан.		

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2025 оноос эхлэн нэвтрүүлэх дэвшилтэт технологийн тэргүүлэх чиглэлийн төсөл, тэргүүлэх чиглэлд нийцсэн төсөл арга хэмжээний саналын жагсаалтыг эцэслэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/235 дугаартай тушаалаар батлуулав.		
ГУРАВ. СУРГАЛТ, СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ							
3.1	Эрүүл мэндийн салбарт шинээр нэвтрүүлэх технологид үнэлгээ хийх арга, аргачлалын сургалт	Сургалтын тоо		Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, менежерийг сургалтад хамруулсан байна.	Их Британийн Эрүүл мэнд, халамжийн үндэсний хүрээлэн /NICE/ хамтран "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад технологийн үнэлгээг хэрэглэх нь" сургалт, салбар хэлэлцүүлгийг 2025 оны 3 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Шангрила, Бодь цамхагийн Дорчистер клуб-д тус тус зохион байгуулсан. ЭМЯ-ны АУИТХ, ЭМДЕГ, ЭЭХХЗГ, ЭМХТ-Төрөлжсөн мэргэжлийн төвүүдийн 100 мэргэжилтийг хамруулан Эрүүл мэндийн технологийн үнэлгээ хийж эмнэлзүйн удирдамж тусгах талаар арга зүйн сургалт хийгдсэн.	I-VI сар	100
3.2	Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.24. дэх заалт "Эрүүл ирээдүй-хүүхэд наснаас" Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурагчдад эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах	Эрт илрүүлгийн хамрагдалтын хувь ЗЦБ-ийн аппаратын хангалтын хувь Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо, зохион байгуулсан сургалтын тоо	2024 онд Нийслэлийн ЕБС-ийн 1-р ангид элссэн 40763 хүүхэд хамрагдахаас 89.69% нь хамрагдсан		Эрүүл мэндийн болон Боловсролын сайдын 2024 оны 9/10 өдрийн А80/А384 тоот тушаал гарч 2024 онд ЕБС-ийн 1-р ангид элссэн 78000 хүүхдэд нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх чиглэлээр давхардсан тоогоор 1844 мэргэжилтнийг сургалтад хамруулсан байна. Сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн зохион байгуулахаар орон нутгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг 404 ширхэг ухаалаг зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангасан. Орон нутгийн сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэг 2025 оны 04 сарын 15-ны өдрөөс эхэлсэн ба ЕБС-ийн 1-р ангийн 38719		100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					сурагч хамрагдахаас 99% хамрагалттай буюу 38365 хүүхэд давхардсан тоогоор хамрагдсан байна. Уг илрүүлэг зүрх, нүд, шүдний үзлэг гэсэн 3н чиглэлд хийгдсэн бөгөөд үзлэг тус бүрээр авч үзвэл шүдний үзлэгийн хамрагалт 93.4%, үүнээс шүдний өвчлөлтэй 67.9%, эмчлүүлсэн 93.2%, нүдний үзлэгийн хамрагалт 85.8%, илрүүлсэн 15%, дараагийн шатны хамрагалтад 4.91%, зүрхний илрүүлэгт 93.7%, зүрхний цахилгаан бичлэгийн өөрчлөлттэй 20.7%, зүрхний хэт авиан оношилгоонд 52.7%, үүнээс 424 зүрхний эмгэг оношлогдож, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж эхлээд байна.		
3.3	Хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор хүүхдийн эмч нарын үндэсний зөвлөгөөн зохион байгуулах;	Ажлын хэсгийн тушаал, удирдамж Зохион байгуулсан зөвлөгөөний тоо Оролцогчдын тоо	-	Ажлын хэсгийн тушаал, удирдамжийг боловсруулж батлуулах, зөвлөгөөнийг зохион байгуулах Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг ЭМБ-уудад хүргэнэ.			0%

Нэг. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээний)-ын биелэлт


Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийн				Эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийн стандартчиллын техникийн хороо (ТХ 06)-ны 2 удаагийн хурлыг удирдан	I-VI сар	100

	стандартчиллын техникийн хороо (ТХ 06)-нд удирдах				явуулж, нийт 7 стандартын төслийг хэлэлцсэн.		
2	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/146 дугаар тушаалаар байгуулсан Эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журам болон лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт судалгааг хийх журам боловсруулах ажлын хэсгийг ахалж байна.				Ажлын хэсгийг 3 удаа удаа хуралдуулж, шинэ эмийн эмнэлзүйн туршилт судалгаа явуулах журмын төслийг боловсруулсан. Лабораторийн оношлуурын эмнэлзүйн туршилт явуулах журмыг боловсруулж байна.	IV-VI cap	100
3.	Эрүүл мэндийн салбарын бүсчилсэн хөгжлийн зорилт, арга хэмжээг тодорхойлох ажлын хэсэгт ажиллах	/	/	/		IV-VI cap	100

ТАЙЛАН ХЯНАСАН:

Анагаах ухааны инноваци, технологийн хэлтсийн дарга

(Албан тушаал)

/  /

(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)

ТАЙЛАН ГАРГАСАН:

Анагаах ухааны инноваци, технологийн хэлтсийн Эрүүл мэндийн шинэ технолог, инноваци хариуцсан ахлах шинжээч
(Албан тушаал)

С.Энхцолмон /  /

(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)